

МОНГОЛ УЛСЫН САЙД, ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ
ГАЗРЫН ДАРГА, УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН
САЙДЫН ХАМТАРСАН ТУШААЛ

2021 оны *08* дугаар
сарын *26*-ны өдөр

Дугаар *16/А/32*

Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 12, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3, 7.4, Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.3, Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор баталсан “Дотоод аудитын дүрэм”-ийн 5.1, 5.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Эрдэнэс Монгол” ХХК, “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” ХХК-ийн 2019 он, 2020 оны санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийх үүрэг бүхий Ажлын хэсгийг дараахь бүрэлдэхүүнтэй байгуулсугай:

- Ахлагч: Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга Э.Бат-Идэр
- Гишүүд: Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Засгийн газрын референт Д.Болд
- Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Газрын тосны бодлогын хэрэгжилтийг зохицуулах хэлтсийн дарга Ч.Чулуунбат
- Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Техник, технологийн хэлтсийн дарга Ч.Цогтбаатар
- Сангийн яамны Худалдан авах ажиллагааны бодлогын хэлтсийн дарга Ц.Батзул
- Сангийн яамны Худалдан авах ажиллагааны бодлогын хэлтсийн ахлах шинжээч Ч.Баярмаа
- Сангийн яамны Санхүүгийн хяналт, эрсдэлийн удирдлагын газрын ахлах мэргэжилтэн, улсын ахлах байцаагч О.Энхжаргал
- Сангийн яамны Санхүүгийн хяналт, эрсдэлийн удирдлагын газрын ахлах мэргэжилтэн, улсын ахлах байцаагч Д.Гэрэл

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын Төрийн өмчийн хяналт шалгалтын хэлтсийн ахлах мэргэжилтэн, улсын ахлах байцаагч Д.Сувдмаа

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын Төрийн өмчийн хяналт шалгалтын хэлтсийн мэргэжилтэн, улсын байцаагч А.Алтаншагай

Нарийн бичгийн дарга: Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын ахлах шинжээч, улсын ахлах байцаагч С.Энхзориг

2. Дотоод аудитын удирдамжийг хавсралтаар баталсугай.


3. Дотоод аудитыг 2021 оны 3 дугаар сарын 1-ний өдрөөс 4 дүгээр сарын 9-ний өдрийг дуустал ажлын 30 хоногийн хугацаанд гүйцэтгэн дүнг 2021 оны 2 дугаар улиралд багтаан Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Дотоод аудитын хороонд танилцуулахыг Ажлын хэсэг (Э.Бат-Идэр)-т даалгасугай.

Монгол Улсын-сайд,
Засгийн газрын Хэрэг
эрхлэх газрын дарга



Ц.НЯМДОРЖ

Уул уурхай, хүнд
үйлдвэрийн сайд



Г.ЁНДОН

Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, Уул уурхай хүнд үйлдвэрийн сайдын 2021 оны 16/А/32 дугаар хамтарсан тушаалын хавсралт

ДОТООД АУДИТЫН УДИРДАМЖ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Дотоод аудитад хамрагдах төрийн өмчит хуулийн этгээд: “Эрдэнэс Монгол” ХХК, “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” ХХК;

1.2. Дотоод аудит хийх үндэслэл: Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 12 дахь хэсэг, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3, 7.4 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг, Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Дотоод аудитын дүрэм”-ийн 5.1, 5.2 дахь хэсгийг үндэслэн дотоод аудит хийнэ;

1.3. Дотоод аудитын зорилго: Энэхүү дотоод аудит хийх удирдамжаар тухайн байгууллагын үйл ажиллагаа нь Монгол Улсын Засгийн газрын тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, холбогдох бусад хууль тогтоомж, эрх бүхий байгууллагаас баталсан тогтоол, заавар, журамд нийцэж байгаа эсэхэд дотоод аудит хийж, дүгнэлт гаргах, түүний мөрөөр зохих арга хэмжээ авах, зөвлөмж өгөхөд оршино;

1.4. Тус компаниудын удирдлага болон холбогдох ажилтан дотоод аудитын ажлын хэсгийг шалгалт хийх нөхцөл бололцоогоор хангаж, холбогдох ажилтнуудыг тайлан мэдээ, санхүүгийн болон бусад баримт материалын хамт шаардсан хугацаанд бэлэн байлгана.

Хоёр. Дотоод аудитын ажлын хамрах хүрээ

“Эрдэнэс Монгол” ХХК, “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” ХХК-ийн 2019 он, 2020 оны удирдлага, санхүүгийн үйл ажиллагаанд дараахь чиглэлээр дотоод аудит хийнэ. Үүнд:

2.1. Санхүү, эдийн засаг, үйлдвэрлэл, үр ашгийн байдал

2.1.1. Компанийн үндсэн үйл ажиллагаа, бүтэц зохион байгуулалт, төлөвлөгөө, гүйцэтгэл, санхүү, эдийн засгийн өнөөгийн байдал, нягтлан бодох бүртгэл, дансдын журнал;

2.1.2. Компанийн үйлдвэрлэл, орлого, өртөг, зардлын бүтэц, орлого нэмэгдүүлэх, зардлыг бууруулах талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээ;

2.1.3. Компанийн суурилагдсан хүчин чадал, техник, тоног төхөөрөмжийн ашиглалт, технологийн шинэчлэлтийн байдал;

2.1.4. Дотоод, гадаадын хөрөнгө оруулалт, төсөл, хөтөлбөр, хандив, зээл тусламжийн эх үүсвэрээр бий болсон хөрөнгийн зарцуулалт, эргэн төлөлт, үр өгөөжийг тооцох;

2.1.5. Компанийн санхүү, эдийн засаг, үйлдвэрлэлийн үйл ажиллагааны үр дүнгийн байдалд шалгагдаж буй хугацааны санхүүгийн тайлангийн үзүүлэлтийг дүгнэх;

2.1.6. Охин компани түүний үйл ажиллагааны өнөөгийн байдал, "Эрдэнэс Силвер Ресурс" ХХК-ийн зардлын зарцуулалт.

2.2. Төрийн өмчийн эд хөрөнгийн бүрэн бүтэн байдал, эзэмшилт, ашиглалт

2.2.1. Биет ба биет бус хөрөнгийг олж бэлтгэсэн хөрөнгийн эх үүсвэрийн байдал, түүний бүтэц, бусдад шилжүүлсэн, худалдсан, акталж устгасан зэрэг эд хөрөнгийн хөдөлгөөн, элэгдэл тооцсон байдал;

2.2.2. Түүхий эд, бараа материал, сэлбэг хэрэгслийн зарцуулалт, төлөвлөлтийн байдал, үлдэгдэл, түргэн хөрвөх зохистой эсэх, насжилт;

2.2.3. Барилга, үндсэн хөрөнгийн түрээсийн гэрээний үндэслэл, түрээсийн төлбөрийн төлөлтийн байдал;

2.2.4. Байгууллагын гэрчилгээ, лиценз, тусгай зөвшөөрөл, газар, бусад эрхийн эзэмшилт.

2.3. Мөнгөн хөрөнгийн зарцуулалт

2.3.1. Харилцах болон бэлэн мөнгөний дансдын орлого, зарлагын гүйлгээг хууль тогтоомжийн дагуу гүйцэтгэж байгаа байдал;

2.3.2. Богино болон урт хугацаат хөрөнгө оруулалт, урьдчилж төлсөн зардлын талаарх тушаал, гэрээ хэлцэл зэрэг эрх зүйн болон анхан шатны баримт материалын үндэслэл, дараа тайлангийн тооцоогоор олгосон мөнгөний баримтын бүрдүүлэлт.

2.4. Авлага, өглөгийн байдал

2.4.1. Авлага үүссэн үндэслэл, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тогтоосон хугацаанд тооцоо нийлж, үлдэгдлийг баталгаажуулсан байдал;

2.4.2. Авлагын насжилт, найдваргүй авлага, найдваргүй авлагын нөөцийн сан, эрх зүйн үндэслэл;

2.4.3. Өр төлбөр, өрийн бичиг, түүний насжилт, урт болон богино хугацаат зээлийн зориулалт, ашиглалт, үр ашиг, төлөлтийн байдал.

2.5. Худалдан авах ажиллагаа, гэрээ хэлцэл

2.5.1. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хэрэгжилт, худалдан авалтыг төлөвлөсөн, зохион байгуулсан, тайлагнасан байдал;

2.5.2. Байгууллага, иргэдтэй байгуулсан гэрээний үндэслэл, гэрээний үүргийн хэрэгжилт, өгөөжийг тооцож, дүгнэх.

2.6. Байгууллагын удирдлага, түүний багийн үйл ажиллагаа

2.6.1. Хувьцаа эзэмшигчдийн хурал болон Төлөөлөн удирдах зөвлөлийн тогтоол, Гүйцэтгэх захирлын тушаал шийдвэртэй танилцаж хэрэгжилтийг дүгнэх;

2.6.2. Гүйцэтгэх захиралтай байгуулсан хөлсөөр ажиллуулах гэрээ, түүний биелэлт;

2.6.3. Өмнө хийгдсэн бусад байгууллагуудын хяналт шалгалт, илэрсэн зөрчил, дутагдал, акт, түүний мөрөөр зохиосон ажил;

2.6.4. Компанийн дотоод аудитаас өгсөн үүрэг даалгаврын биелэлт, гүйцэтгэх захирлын ажлыг дүгнэсэн байдал.

Гурав. Дотоод аудитын дүн гаргах:

3.1. Дотоод аудитын ажлын хуваарийг ажлын хэсгийн ахлагч гаргана. Ажлын хэсгийн бүрэлдэхүүн хуваарийн дагуу ажиллана;

3.2. Ажлын хэсгийн гишүүд хуваарийн дагуу зөвхөн өөрийн хамааралтай баримт материалыг цуглуулан шалгалт хийж, тайлан боловсруулан, ажлын хэсгийн нарийн бичгийн даргад өгч нэгдсэн тайлан гаргана. Ажлаа гүйцэтгээгүй бол холбогдох ажилтан өөрөө хариуцана.

3.3. Дотоод аудит хийх явцад илэрсэн зөрчил, дутагдалд дүгнэлт хийж, түүнийг арилгах талаар үүрэг даалгавар тухай бүр өгч, тодорхой ажил зохион байгуулж, үр дүнг тайланд тодорхой тусгана;

3.4. Дотоод аудит хийсэн тухай тайланг удирдамжийн дагуу бичиж, нэгдсэн тайланг удирдлагад танилцуулж, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Дотоод аудитын хороонд танилцуулан авах арга хэмжээний талаар шийдвэр гаргуулж, биелэлтэд хяналт тавьж ажиллана.

---oOo---